

# МОНГОЛ АДУУНЫ ЗҮС ЗҮСЭМ ХИЙГЭЭД ӨНГӨНИЙ БИЛГЭДЭЛИЙН УЧИР ХОЛБОГДОЛ

*Н.Давхарбаяр. БНХАУ, Эрэн хотын Олон Улсын Дээд Сургууль*

**Abstract.** When translating Mongolian lifestyle and Mongolian habitation into a foreign language you have to take into consideration the special characteristics of the origin and techniques to express the accurate meaning.

Even though terms and phrases used for horse complexion are included in Mongolian dictionaries very few are accurately translated into Chinese-Mongolian, Mongolia-Chinese, Chinese-Russian, Russian-Chinese dictionaries, as well as Mongolian and Chinese thesaurus which would all use different terms and phrases. Hence, we who know our livestock better than anyone else are responsible for unifying the terminology used, on the other hand I am sharing with you and promoting my research work in today's culture about this special lifestyle.

**Түлхүүр үг:** Өнгө, монгол адуу, зүс, хээр, нэршил,

## Удиртгал

Сурвалж бичигт тэмдэглэснээр Монгол хүн морийг 6000 жилийн тэртээгээс хань нөхөр мэт санаж, ахуй амьдралдаа хэрэглэж иржээ. Нүүдлийн мал аж ахуй эрхэлж ирсэн Монголчууд олон зууны тэртээгээс адуу малын зүс зүсмийг олон янзаар нэрлэж иржээ. Аливаа хэлэнд үндэсний онцлог бүхий үг хэллэг гэж байдаг бөгөөд тухайн улс орны аж төрлийн өвөрмөц онцлогийг илтгэдэг ажээ. Адуу малын зүс зүсмийг судалж сурвалжилсан эрдэмтэд адууны зүс зүсмийг дэвсгэр зүс 30 гаруй, зүс тодруулсан чимэг үгс 400 гаруй орчим байдаг хэмээн бүтээлдээ дурдсан байдаг. Манайд адуу малынхаа зүс зүсмийг тодорхойлсон толь бичиг, зурагт толь, тайлбар толь одоогоор байхгүй байна.

Чехийн Монголч эрдэмтэн, доктор профессор Иржи Шима Монголын яруу найргийг Чех хэлнээ орчуулах явцдаа Монгол адууны зүс зүсмийг Монголын толь бичгүүдээс эрж хайгаад олоогүй тухайгаа Засгийн газрын мэдээ сонины 1998 оны 7 дугаар сарын 21-ний 145 (1097) дугаарт "Монгол шүлгийг орчуулахад ургамлын нэр, малын зүс их хэцүү. Монгол яруу найрагчдын бүтээлд ургамал, мал ер байгалийг маш их дүрсэлсэн байдаг. Толь бичгээс морины зүсний орчуулгыг олж чадаагүй. Монгол шиг олон үстэй морь байхгүй билээ" хэмээн ярилцлагандаа дурьджээ. Мөн Японы эрдэмтэн Монголч эрдэмтэн Койбүчи Шиничи мөн адууны зүсийг дэвсгэр зүс 30 гаруй, зүс тодруулсан чимэг үгс 400-500 орчим байна хэмээсэн нь зүс зүсмийг нэрлэсэн тоо энэ багцаа байгаа хэмээх ойлголтод хүргэж байна.

Бид энэхүү судалгааны өгүүлэлдээ адуу малын зүс зүсмийг гадаад хүнд ойлгогдохоор буутал ойлгуулах нь аль ч гадаад хэлний мэргэжилтэн,

орчуулагч, хэлмэрчийн эрхэм үүрэг юм. Иймээс энэхүү үйлсэд өчүүхэн болтугай нэмэр болгохын үүднээс адуу малын зүсийг хэрхэн оноон орчуулбал зөв оновчтой болох талаарх судалгааны үр дүнгийн нэгээхэн хэсгийг танилцуулж байна.

Түүнчлэн адуу малын зүс зүсмийг нэг мөр болгосон толь бичиг хэрэгтэй байгаагийн зэрэгцээ ерөөс мал аж ахуй эрхэлдгийнхээ хувьд мал ахуйнхаа тухайд үг хэллэг, нэр томъёог гадаад хэлээр оноон орчуулж өгөх явдал чухал хэрэгцээтэй тул адуу малын гол дэвсгэр зүсмийн асуудлыг судлав.

## 1. Адуу малын зүс зүсмийн түүхэн ойлгоц.

Монгол овогтон өлгий нутагтаа ан амьтан гаршуулж малжих суурийг тавьсан цагаас сүрэг олшрох тутам түүнийг хооронд нь ялган таних, хувийн өмч үүсмэгц гаршуулсан мал амьтныг чиний, миний гэсэн ялгавартай болгохын тулд малын биеийн галбир, өнгө зүсмээр нь ялган нүдлэхээс эхлэн олон зуун жилийн ажиглалтаар мэдэж тохирсон нэр томъёог бий болгожээ.

Монгол хэл малын зүс зүсэм (тэр тусмаа адууны) үгсээр маш баялаг болохыг монгол ардын аман зохиолоос тодорхой үзэж болно. Ер нь хүн төрөлхтөн аливаа зүйлийг танин мэдэхдээ бодитой хүртэгдэх шинжээс нь эхлэн тусгаад дотоод мөн чанарт нь нэвтэрдэг нийтлэг онцлог харагдаж байна. Малын зүс заасан тэмдэг нэрийг ажиглахад адуу малын зүс зүсэм заасан тэмдэг нэр хамгийн түгээмэл байдгийг монгол ардын аман зохиолын аль ч төрлөөс төвөггүй мэдэж болно. Сэцэн хан аймгийн Хэбэй ван Тогтохтөрийн (То ван) 1853 онд бичсэн аж төрөхийн сургаалд: "Гаднаас орж ирсэн хүнийг хэр зэрэг малчин болохыг мэдье гэвэл мал асуу, хэрэв сайн малчин бол замд үзсэн

малыг тоо зүсээр нь хэлдэг. Муу малчин бол юу ч үзэлгүй орж ирж айлын цай үхэр мэт сорон ууж малаас айл дамжин хэсдэг" хэмээжээ. Энэ нь зөвхөн То вангийн сургаал биш монголын нийт ард түмэн хүний өөрийн нийт мал сүргийг нүдлэн хамгаалж, малд гярхай хандаж ирснээс үүдэн гарсан сургааль юм.

Аливаа ард түмний түүх, соёлын үнэт өвийн нэг нь тухайн үндэстний ардын аман зохиол билээ. Энэ үүднээс Монгол ардын аман зохиол болох (үлгэр, уртын дуу, богино дуу, оньсого, ертөнцийн гурав, зүйр цэцэн үг, тууль, магтаал, ерөөл, зугаа үг, жороо үг, бэлэг дэмбэрэлийн үг, домог)-оос адуу (морь)-ны зүс шинжийг заасан үгсийг түүж бүрэлдэхүүн утга зүйн онцлогийг тодорхойлон үзвээс сонин дүгнэлт гарч байна.

Үзэж харсан судалгааныхаа материалаас үзэхэд үндсэн гэж нэрлэх 30 гаруй зүсийг үндсэн долоон өнгийн дарааллаар жагсаавал: хар, халтар, хүрэн, хээр, халиун, зээрд, улаан, ухаа, цавьдар, загал, буурал, бор, хөх, саарал, цагаан, ягаан, цэнхэр, хул, хонгор, хондон, шарга, борлог, харлаг, алаг, цоохор, халзан, толбот, бидэрт гэхчилэн зүс байгаа бөгөөд Монголчууд эдгээр зүсийг ерөнхийлөн бүлэглэж бараан, бүгээн, алаг зүсэм гэж нэрлэсээр иржээ.

Эрдэмтэн Леонтьев өөрийн бүтээлдээ Орос хэлэнд морины явдлыг (хатирах, цогих, давхих, шогших.....) гэсэн цөөн үгээр илэрхийлдэг тухай дурдсан нь бий. Энэ нь тухайн ард түмний мал аж ахуйг эрхлэх онцлогоос хамааралтай. Тэгвэл монгол хэлэнд морины явдлыг алхах, шогших, хатуу шогших, хатирах, жороолох, цогих, сэгэх, давхих, таваргах, сайварлах, сүүл хөдөлгөх гэх зэргээр нэрлэдэг. Зөвхөн жороо хэмээх явдлыг удган хатираа, түргэч, хонин жороо, тэмээн жороо, усан тэлмэн жороо, унаган жороо, албадан жороо, дээгүүр жороо, доогуур жороо гэхчлэн ялгадаг. Энэ бүхнийг дурдахын учир гэвэл монгол хэлэнд адуу (морины) зүс шинж заасан үг хэр зэрэг баян болохыг нээн үзүүлэх гэснийх билээ.

Монголчууд малын зүсийг тодруулан ялгахдаа үлэмж нарийн юм. Малыг зүсээр нь ялгаварлан нүдлэх арга энгийн боловч маш олон төрлийн дан ба нийлмэл зүснээс бүрдэнэ. Малыг хар, улаан, цагаан гэсэн нэг үгнээс бүрдсэн дан зүсээр зүслэн нэрлэх боловч бас алаг, хар цоохор, ягаан буурал гэх мэт хоёр үгнээс бүтсэн нийлмэл зүс байдаг. Манай орны олон ястангууд малын зүсийг ойролцоо хэллэгээр нэрлэх боловч зарим өвөрмөц ялгаа бас байдаг.

Монгол хэлэнд хээр зүсийг хар хээр, улаан хээр, шар хээр, бор хээр, хээр халтар) гэж ялгах ажээ. Алтай язгуурын хэлнүүдэд адууны зүс

шинж заасан монгол үг хэллэг элбэг байх ажээ. Үүний жишээ болгон казак хэлэнд тохиолдож буй морины зүс заасан үгийг авч үзье. Казак хэлний боз (бор), кек (хөх), ала (алаг), жагал (загал), жирэн (зээрд), кара (хар), кулагөр (ухаа хонгор), күрэн (хүрэн), шавдар (цавьдар) зэрэг зүс заасан үгс нь түрэг хэлэнд малын зүс заасан монгол үг олон байгааг харуулж байна. Дээрх зүс заасан үг нь авианы яльгүй өөрчлөлт байгааг эс тооцвол жинхэнэ монгол хэлний үг болох нь тодорхой. Тэр ч бүү хэл казак хэлэнд "ЗҮС" гэдэг үгийг жүч, дүз, түс хэмээн нэрлэдэг. Манж-түнгүс хэлний зүс заасан зарим үгийн утгын тайлбарыг энд дурдая. Тухайлбал, манж хэлэнд (заха, захала) гэдэг үгийг "хүзүү цээжиндээ хар буюу улаан зураас судалтай, хүзүү ба хөлдөө хүрэн толботой зүс" хэмээн тодорхойлжээ. Энэ нь манайд одоо "загал" хэмээн нэрлэж байгаа адууны зүсний тодорхойлолттой яв цав нийлж байна.

Ер нь алтай язгуурын хэлнүүдийн адууны зүс шинжийг заасан үгс нь монгол хэлнээс үүсэлтэй гэж үзэж болно. В.И.Цинциус, Г.М.Василевич, К.А.Новикова, Г.Д.Санжеев, Чой.Лувсанжав нар монгол хэлний "морь", "чихтэй" зэрэг үг манж, хамниган хэлэнд орсныг нотолжээ. Адуу морины зүс заасан үгс тэмдэг нэрийн үүслийн нэгэн адил нэлээд эрт үүссэн гэж хэлж болно.

Адууны зүсийг тодотгон чимэх нэрс монгол хэлэнд үлэмж элбэг байдаг. Тухайлбал, агсал, агт, аргамаг, дөмөлзсөн, долгин гэхчлэн олон зуун үг байгаа юм. Ийм үгс нь аман зохиолын төрлүүд дотроос ард түмний сэтгэлийн хөдөлгөөнийг хамгийн их илэрхийлдэг уртын уянгалаг дуунд бусад төрлөөс олон тохиолдож байгаа нь Монголчууд уртын дууг "эмээлийн дуу" хэмээн нэрлэдэгтэй ч холбоотой байж болох юм. Үүнээс гадна адууны зүс заасан тэмдэг нэр нь хул, саарал, хөвхөр, халзан, загал, халиун, хонгор, зээрд, ягаан, буурал, толбот, бидэрт гэх зэргээр харьцангуй нэршсэн үгээр илэрсэн үгс (зүс) байгаа нь ажиглалтаас харагддаг. Морь малын зүс заасан үгийг нягтлан ажиглаж үзэхэд бүтцийн хувьд үндсэн зүс, зүс тодруулан чимэх нэрс, тодотгон чимэх нийлмэл үгс зэргээс бүрдэж байна. Зүс тодруулан чимэх үгийг утгын хувьд ангилж харвал гадаад төрх, галбир заасан (далбалзсан хүрэн, цомбон туурайтай хүрэн, дандгай цээжтэй хүрэн) нас хүйсийг ялган заасан (дааган, дааган хар, дөрвөн настай халиун, гунан хар) шинж чанар заасан (агсал хул, ардаг баахан шарга) үндсэн зүсийг тодруулан заасан (буурал халзан, шар хээр, хар хээр; амьтан юмс үзэгдэлтэй адилтган тодотгосон (ирвэс хээр, арслан хээр морь, хайчин чихтэй хар) гэхчилэн зүсэлсэн байдаг.

Адуу (морь)-ны зүсийг тохиолдох байдлаар нь элбэг, ховор зүс гэж ангилах тал бий. Морины зүс заасан үгсийн хэмжээнд хамгийн элбэг, хамгийн ховор зүсийг тодруулж бас болно. Миний ажигласнаар хээр, бор, хүрэн, шарга зүс элбэг байхад хөх, ягаан, улаан, хонгор зүс төдийлөн элбэг биш байх жишээтэй. Дээр дурдсан шинжтэй шарга зүс нь ардын аман зохиолын төрөл зүйлд элбэг байгаа боловч бодит амьдрал дээр цөөн юм. Энэ нь хүндэтгэлтэй холбоотой байж ч магадгүй юм. Эндээс үзвэл адууны зүс, түүнийг хүндэтгэн билэгшээх ёс заншил нь тухайн улс орны нийгэм түүх, шашин шүтлэгийн өөрчлөлтийг даган өөрчлөгдсөөр иржээ. Үүний нэгэн жишээ нь шарга зүсийг галыг дээдэлдэг, эрхэмлэн шүтдэг Монголчуудын шүтлэгтэй холбоотой хэмээн үзэж болох талтай. Мөн бөө мөргөл, тэнгэрийг шүтдэг тэр цагаас цагаан зүсийг илүүтэй эрхэмлэдэг болжээ. Цагаан зүсмийн адуу нь элбэг биш. Монголчууд цагаан зүсний адууг бор морь, саарал морь гэж эерүүлэн нэрлэх ёс ч бий. Учир нь тэнгэрийн унаа бол цагаан зүстэй байх учир нэрийг нь тэр чигээр нь хэлэхээс цээрлэхийн бор дүрхэн, бор гэж зөрүүлдэг байх жишээтэй. Цагаан зүсмийн болох унага хар бараан төрөөд яваандаа цайрдаг. Мөн цагаан гүүний сүү элэг цөсний болон уушигны сүрьеэ зэрэг өвчинд сайн байгаа зэрэг нь мөн түүний зүстэй холбогдож байна. Анагаах ухаанд хэт ягаан туяаны эмчилгээг дээрх өвчнүүдийг анагаахад ашиглаж байгаа нь үүнтэй тохирч байна.

Монгол адууны хамгийн түгээмэл зүс бол хээр зүс юм. Хээр зүсний адуу монгол адуун сүргийн талаас хол илүү хувийг эзэлж байна. Азарга азаргаар бэлчиж яваа адуун сүрэг хээртэн бараантаж харагддаг. Ардын аман зохиолд ч хээр зүсмийн адууны тухай их бичсэн байдаг. Хээр зүс түгээмэл байгаа нь монгол адууны уугуул зүс байж болно. Үүнийг тодруулахын учир хэд хэдэн чиглэлээр санаа нэмэрлэе . Үүнд:

- "... Уул талыг бүрхсэн Улаан хээр адууны Буян хишиг дэлгэрэг..."

(Таван хошуу малын магтаал)-д гэж байгаагаас үзвэл "Хээр" нь монгол адууны үндсэн зүс болохын нэг баталгаа юм .

- "Алтай дээгүүр гүйгч Алаг нүдэн хээр ..." (Уртын дуу)
- Өндөр хээр нь Ижил дундаа янзтай ....(Өндөр сайхан хээр)
- "Бандан хээрийг унаюу даа хө

Баруун шилээр бөмбөрүүлжээ хө ... " (Бандан хээр) гэх зэрэг олон арван дуунд "хээр" зүсмийн морины тухай дүрсэлж байх юм .

- Хээр зүсмийн морийг Өвөр Монголын

зарим хошуудад тэнгэрийн хүлэг хэмээн хүндэтгэж байсан баримт ч гарч байна .  
"Баянголын сүм " гэдэг дуунд :

Дөрвөн хээр гэдэг

Тэнгэрийн гүүний унага..."Монгол ардын мянган дуу (Хөх хот. 1983.х.95)

"Ар талын арц " гэдэг дуунд

" Дөрвөн хээр тэнгэрийн унаа

Дөрвөлжин харагдах миний нутаг..." гэж дуулдаг байна .

Монгол хүн адууг түүхийн нэгэн үед зэрлэг овгоос анх барьж авсан анхны адуу нь "хээр" зүстэй байсан байж болох юм. Ийнхүү хээрээс барьсан учраас тэр газрынх нь нэрээр нэрлэе гэсэн үүднээс энэхүү "Хээр" хэмээн зүс гарсан байж болно. Дээр дурьдсан баримтууд хээр зүсийг монгол адууны уугуул зүс болохыг баглах боломж нээж байна .

Дээр өгүүлсэнчлэн монгол адууны уугуул зүс "Хээр" байж болох талтай. Адууг гэрийн тэжээмэл болгосон тэр цагаас хойш тоо толгойн хувьд өсч, нэгийг нь нөгөөгөөс ялгахын тулд зүслэн нэрлэх шаардлага зайлшгүй гарчээ. Ийнхүү нэг хэсгийг нь үзэгдэх харагдах өнгө зүсээр нь, нөгөө хэсгийг нь дүйх дүйцүүлэх зүйлтэй нь холбож, бас зарим хэсгийг нь билэгшээж, цээрлэн зүсэлсээр өнөөдрийн олон зүсэм бий болжээ. Тухайлбал, хулантай төстэйг нь "Хул" гээд, зээртэй ойролцоог нь "Зээрд" гэж нэрлэжээ.

Хүрэн зүс нь монгол адууны үндсэн зүсүүдийн нэг мөн. Үүнийг батлах жишээ ардын аман зохиолд элбэг байгаа хийгээд, бас цуглуулсан баримт жишээ, судалгааныхаа дүгнэлтээс үзвэл хүрэн зүсмийн адуу хурд хүч сайтай болох тал ч байна.

Мөн "Халтар" гэдэг зүс нь хар тарлан гэсэн үгнээс үүсэлтэй байж болох талтай. Үүнтэй адилаар цавьдар гэдэг зүсэм цагаавтар гэсэн үгнээс гаралтай байж болох юм. Энэчлэн зүс бүхэн өөрийн гэсэн гарал үүсэлтэй.

Ямар ч малд ногоон буюу ногоонтой хосолсон нийлмэл үгээс бүтсэн зүсний нэршил байдаггүй болохоор үлгэр домог, зүйр цэцэн үгэнд оруулж ярьдаг. Хэнтий аймаг болон түүнтэй хил залгаа Дорнод Монголын зарим адуучид бусад нутгийнхан халтар буюу хар саарал гэж нэрлэдэг морийг ногоон морь гэдэг.Энэ нэршил эрт үеэс хэрэглэгдсэн бололтой. Ардын нэг дуунд:

"Ногоон морины толгой дээр Ногтон зангиа бөнжийж байна.

Ноён харуулын Гүнжидмаа Номхон дөлгөөн бүсгүй байна" гэж байдаг. Тэгэхээр адууг ногоон хэмээн зүйрлэн зүсэлж байжээ хэмээн дүгнэж болохоор нэгэн жишээ энэ буюу.

Адууны зүсийг Монголчууд нийтлэг хар, цагаан, хээр, хүрэн гэх мэт дан зүсээр ялгаварлан нэрлэхийн зэрэгцээ хосолсон нийлмэл үгнээс бүтсэн нэр маш олон байдаг ажээ. Адууны хээр зүс дотроо шар хээр, хар хээр, бор хээр, улаан хээр гэх зэргээр үсний голлох өнгийг үндэслэн нэрлэсэн нэршлүүд байдаг.

## 2. Монгол адууны зүсний билгэдэл

Нэгэнт морь малын зүс зүсийн тухай ярьж буй учир Монгол хүний өнгөний бэлэгдлийн тухай цухас дурьдах нь зүйтэй гэж үзлээ. Эртний хүний гэнэн сэтгэлгээнд байгалийн юм үзэгдлийн өнгө дүр, хэлбэр галбирыг товойлгон дүрслэх мэдрэмж буй болсонтой холбогдон тэнгэрийн тухай анхны төсөөлөл бий болжээ. Хүний амьдралын үйл явцаас улбаалж билгэдэлт сэтгэлгээ, билгэдэлт ухагдахуун бий болсон байна. Энэхүү билгэдэлт ухагдахуун цааш улам гүнзгийрч, улс төр, иргэний шинжтэй ахуйн холбогдолтой билгэдэлийг бий болгожээ. Ахуйн билгэдэл нь тоо, өнгө, зүг чиг, дүрс, үйл явц хөдөлгөөн зэрэг асар өргөн хүрээтэй билээ.

Монголчуудын билгэдэх ёсны тухай асуудал сүүлийн үед судлаач, шинжээчдийн анхаарлыг татаж байна.

Оросын эрдэмтэн П.Л.Шатина өнгөөр чимэглэн нэрлэх нь чухамдаа тухайн ард түмний угсаатны зүйн зарим онцлогтой холбоотой бололтой хэмээн нэгэн судалгаандаа дурджээ. Солонгосчууд "Цагаан" гэсэн чимэг зүүх нь тэдний байнга өмсдөг өмсдөг хувцасны өнгө байж болох талтай. Тангад төвдийг "хар" гэх нь сарлагийн хар хялгасаар өөрсдийнх нь нэхэж хийсэн хар асар-банагийн өнгө ба тангадууд төвдийн умарт хязгаарт нүүдэллэн аж төрдөг. Туркестанд амьдран суудаг олон ястан "Шар" хэмээх чимэг зүүсэн нь шавар эдлэл барилгынх нь өнгө бололтой. Монголчуудыг "Хөх" хэмээх нь мөнх хөх тэнгэрийг шүтдэг бөө мөргөлийн учир байж таарна. Бөө мөргөлийн үзэлд тэнгэрийг цэнхэр өнгө нь байлдан дагууллын үеийн Монголчуудын ноёлох байр суурьтай холбоотой бөгөөд чухам эндээс "Хөх Монголчууд" гэдэг нэр гарчээ.

Өнгөөр бэлгэдэх ёс гүн ухаан, ёс зүйн утгатай төдийгүй угсаатны зүйн ялгах тэмдэг болдог онцлогтой байна. Академич Б.Ринчин "Манай Монголын соёлын өвөөс" гэдэг өгүүлэлдээ Монгол угсаатны уламжлалт соёл урлагийн бүтээлд хийсвэр үзэл ойлголтыг өнгөөр тэмдэглэх заншил байсан бөгөөд хөх өнгөөр үл хөдлөх хөрвөх мөнх юмыг эсвэл үнэнч сэтгэлийг, шар өнгөөр хайрлах талархах сэтгэлийг, улаанаар баяр баясгаланг, хараар гай зовлон аюул түгшүүрийг

тус тус илэрхийлж байжээ" хэмээны тэмдэглэсэн байдаг. (Ринчен, 1958, х.62)

Тэгвэл эрдэмтэн С.Дулам Монголчуудын өнгөөр билэгдэх ёсны тоймыг нэгтгэн дүгнээд, Монголчууд тэнгэрийг өнгөөр нь төлөөлүүлж "хөхрөгч" гэж хөх өнгөтэй нь адилтган нэрлэдэг юм. Олонх улс үндэстэнд галыг улаан, улбар, агаарыг шар, цагаан, усыг ногоон, газрыг хар хүрэн гэж нэг янзаар үзэж сэтгэдэг боловч Монголчуудын дунд тэдэнтэй нийтлэг зүйл байхаас гадна газар шороог "Бор", булаг усыг "Хар", ногоог "Хөх" гэж үздэг өвөрмөц зүйл бас байна. (Дулам, 2002, х.56) Эрдэмтэн Х.Нямбуу 1979 онд бичсэн "Монголын билэгдэл" гэдэг номондоо голдуу төрийн билэгдлийн төрөл үүсэл, утга учрын тухай бичсэн байна.

Ертөнцийн аливаа юм үзэгдэл тодорхой дүрс хэлбэр шинж чанартай байхаас гадна өнгөтэй байдаг. Хүн төрөлхтөн тойрон хүрээлж буй байгал дэлхийнхээ өнгийг мэдэрч эхэлсэн тэр үеэс өөр өөрсдийн ахуйн амьдрал, зан заншил шүтлэг бишрэлээс болж зарим өнгийг билэгшээн талархаж, заримыг нь таашаадаггүй болсон нь мэдээж хэрэг.

Иймээс өнгө бол мандал, бадрал, эрүүл энх, баяр баясгаланг илтгэсэн тодорхой бэлэгдлийн утгатай. Хөх өнгө бол тэнгэрийн өнгө, мөнхийн бэлгэ тэмдэг болно. Шар бол алтны өнгө бөгөөд хайр талархлыг илэрхийлнэ. Улаан баяр баясгалангийн өнгө. Цагаан бол цэвэр ариун өнгө. Хар бол зовлон гамшиг, аюул тэрслэлийн өнгө болно. (Майдар, 1982, х.12)

Алт бол өнгө хувирдаггүй арчих тутам улам өнгө ордог тул алтны шар өнгийг хайртай юм уу, эрхэм нандин гэсэн санааг илтгэх болжээ. Улааныг Монголчууд эртнээс нааш баяр баясгалангийн өнгө гэж үздэг. Цагааныг хиргүй ариун гэсэн утгатай гэж үздэг тул сайхан санааг цагаан санаа, сайн сайхан юмыг цагаан зүгийн юм хэмээн үзнэ. Хөх өнгийг тэнгэрийн өнгө хэзээ ч хувирдаггүй бат, мөнх үүрд гэсэн утгатай. Тэгээд ч гашуудал бэлэвсрэлд Монголчууд хөх өнгө хэрэглэдэг байсан нь хэзээд мартаггүй дурсаж явна гэсэн санааг хөх өнгөөр илэрхийлнэ. Хар өнгө бол Монгол ардын уламжлалт хольцоогүй гэсэн утгатай. (Ринчен, 1971, х.51)

Монгол түмэн өөрийн эрхэмлэн дээдэлдэг цээрлэн зэвүүцдэг өнгөтэй ажээ. Эрт цагаас солонгын долоон өнгөөс улаан, шар, хөх гурвыг анхдагч, ногоон, хөх, ягаан, улбар шар өнгийг хоёрдогч өнгө хэмээн хэлэлцдэг. Монголчууд улаан, шар өнгийг өргөн хэрэглэхээс гадна дээдлэн үздэг учраас эцэг, эхийн сэтгэл шиг цэвэр ариуныг билэгдэх эх, бусад үлдсэн өнгийг хүү өнгө гэж

### 3. Үндэсний онцлог бүхий үг хэллэгийг хэрхэн орчуулах хийгээд нэр томъёог хэрхэн оноох тухай

Хоёр буюу хэд хэдэн хэлний үзэгдлийг харьцуулан үзэхэд аль алинд нь байдаг адил төстэй ерөнхий зүйл арвин байхын зэрэгцээ тухайн ганц хэлэнд л байдаг, бусад хэлээр орчуулахад бэрхшээлтэй онцлог зүйлс бий. Хэлэнд байгаа ерөнхий зүйлийг хэлний нийтлэг гэх бөгөөд онцгойг нь үндэсний онцлогтой үг гэж нэрлэдэг. Өөрөөр хэлбэл тухайн улс оронд ард түмний амьдрал ахуй, зан заншил, соёл иргэншил, нийгмийн байгууллын онцлогийг тусгасан эд өлөг, үзэгдлийн нэр агуулгыг тэр улс түмний хэлээр илэрхийлсэн бөгөөд бусад хэлээр шууд орчуулж болошгүй үг, нийлэмж үгийг үндэсний онцлогтой үг буюу реали үг гэж нэрлэдэг. Энэ нь тухайн үндэстний аж төрж буй цаг үе, нийгэм, соёл, газар нутгийн ялгаа, хүн ардын өвөрмөц ахуй амьдрал, зан заншилын дадал хэвшилтэй холбоотой юм

Иймд таван хошуу малаа түшин аж төрж ирсэн Монголчуудын адуу малын зүс зүсмийн нэрийн зүйл нь гарцаагүй үндэсний онцлогтой үгс мөн. Адууны зүс зүсмийн нэрийн зүйл нь ч үндэсний онцлогтой үгийн гол гол шинжийг агуулж байгаа юм. Үүнд:

- Хоёрдмол утгагүй
- Үндэсний онцлогтой үгс нь тухайн хэлний үгийн сангийн язгуур бүрэлдэхүүн хэсгийн хувьд уугуул хэлний үгийн сангийн бүх шинжийг өөртөө бүрэн агуулдаг.
- Нэр томъёоны бүрэн утгыг илэрхийлж чадна.
- Шинжлэх ухааны зохиол бүтээл, уран зохиол, ярианы хэлэнд зонхилон хэрэглэгддэг.
- Зөвхөн тухайн хэлний хүрээнд бүрэн утгаараа хэрэглэгдцэг боловч гадаад хэлэнд галиглах замаар нэвтрэх ёс бий.

Аливаа хэлний реали үг нийт үгийн сангийн 6-7 хувийг эзэлдэг гэх боловч чанарын хувьд мэдэгдэхүйц жинтэй юм. Реалийн судалгаа нь тухайн ард түмний өнгөрсөн ба ирээдүйн тухай мэдлэг эзэмших, хэлийг нь сурах сонирхлыг өрнүүлж улмаар тэр орны ард түмнийг хайрлах үзэл, хүндэтгэх сэтгэл төрүүлдгээрээ онцгой ач холбогдолтой юм. Ийм учраас адуу малын зүс зүсмийн нэрийн зүйлийг Хятад хэлнээ зөв, оновчтой оноон орчуулах нь чухлаас чухал болоод байна.

Орчуулгын онолоор бол үндэсний онцлог бүхий үг хэллэг, нэр томъёог орчуулах хэд хэдэн

арга байдаг. Үүнд:

- Үндэсний онцлог бүхий үг нэр томъёог нэг хэлнээс нөгөө хэлэнд галиглах буюу дуудлагаар нь буулгах
- Хуулбарлах буюу үгчлэн орчуулах
- Утга ойролцоо үгээр орчуулах
- Тайлбарлан орчуулах.
- Дүйх үгээр орчуулах
- Зүүлт тайлбар хийх арга

Онолын энэ 6 аргаас тайлбарлан орчуулах, дүйх үгээр орчуулах эл хоёр аргыг адуу малын зүс зүсмийг Хятад хэлнээ оноон орчуулсан ажлын үр дүнгээ дараагийн өгүүлэлдээ танилцуулах болно.

## ДҮГНЭЛТ

Монголын эрт эдүгээгийн үлгэр тууль, яруу найрагт амраг сэтгэлт залуусын тухай, адуу морины тухай маш их гардаг бөгөөд ялангуяа адуу, морь малын зүс зүсэм болгон цаанаа өнгөний бэлгэдэлтэй байдаг учир юу юуны өмнө зүс зүсмээ зөв оноож, өнгөний бэлгэдэлтэй нь зөв холбож өгөх нь нэн чухал, эрдэм судалгааны үнэ цэнэтэй зүйл болох учиртай билээ. Монгол ахуй, Монгол аж төрлийн шг хэллэгийг харь хэл рүү орчуулахад уг зүйлээ буюу өөрөөр хэлбэл ахуйн онцлог байдлыг нарийн ойлгож мэдэж байж орчуулах нь чухал байдаг.

Монгол адууны зүс зүсмийн тухай үг хэллэг, нэр томъёо толь бичгүүдэд байх боловч нарийвчилсан үг хэллэгийг оноон орчуулсан байдал нь хэлний их, бага тайлбар толиудад нэг мөр болгон тогтоогүй эсвэл янз бүрээр зөрөөтэй орчуулсан байгааг өөрийн судалгаандаа хөндсөн болно. Тиймээс морины зүсийг хэрхэн нэрлэж болох талаарх оноосон нэршилийг тогтох нь чухал байгааг нь тэмдэглэх нь зүйтэй. Адууны зүсмийг толь бичиг болгонд өөрөөр орчуулсныг цэгцэлж нэг нэршил дээр тогтох нь чухалтай байна.

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Нямбуу, Х.(1979). *Монголын бэлгэдэл*. Улсын хэвлэлийн хороо
- Нямбуу,Х.(2002). *Монголын ёс заншилын их толь*. Улаанбаатар
- Дулам, С. (1992). *Монголчуудын өнгөөр бэлгэдэх ёсны тухай" аман зохиол судлал*. Улаанбаатар
- Майдар, Д. (1982). *Монголын түүх, соёлын дурсгалт зүйлс*.Улаанбаатар
- Ринчин, Б. (1958). *Манай Монголын өв соёл*. Улаанбаатар